

СЭНДБОКСЫН ОРЧНЫ ТОЙМ

2024 оны II улирал

АГУУЛГА

НЭГ.	СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ	3
1.1	Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ	4
1.2	Хамтын санхүүжилтийн үйлчилгээ	6
1.3	P2P зээлийн үйлчилгээ	7
1.4	B2B зээлийн үйлчилгээ	9
ХОЁР.	БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ	10

ХОЛБОО БАРИХ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР,
СЭНДБОКСЫН АЛБА

УТАС: 51-261106

И-МЭЙЛ: SANDBOX@FRC.MN

ХАЯГ: ЗАСГИЙН ГАЗРЫН IV БАЙР, БАГА ТОЙРУУ 3,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, УЛААНБААТАР ХОТ, 15160

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Сэндбоксоод ирүүлсэн хүсэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр

Сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших нийт 20* хүсэлт ирсэн бөгөөд үүнээс 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 1 хүсэлт шинээр ирсэн байна.



Сэндбоксын орчинд орсон бүтээгдэхүүн, үйлчилгээ

2024 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 8 бүтээгдэхүүн, үйлчилгээ сэндбоксын орчинд орсноос 2 үйлчилгээ 1 жилийн хугацаанд туршигдан сэндбоксоос гарч, 3 үйлчилгээ туршилтын хугацаагаа ахин 1 жилээр сунгаж, 3 үйлчилгээ сэндбоксын орчинд шинээр орон туршигдаж байна.



Монпэй дижитал бонд нь 2021.11.01–ний өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд сэндбоксын орчинд туршигдаж 2022.12.30–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчноос гарсан.




Лайка платформоор хүргэж буй инсуртек үйлчилгээ 2022.12.30–ны өдрөөс сэндбокс орчинд туршигдаж 2024.01.26–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчноос гарсан.



ББСБ–уудын репо хэлцлийн зуучлалын платформын үйлчилгээ 2021.12.17–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчинд орсон.



Урамшуулал, хандив, хөрөнгө оруулалтад суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ 2023.11.07–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчинд орсон.



Зээл, урамшуулал, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээ 2022.12.30–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчинд орсон.



Биржийн бус зах зээлийн блокчэйн арилжааны систем 2023.11.07–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчинд орсон.



P2P зээлийн үйлчилгээ 2022.12.30–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчинд орсон.



B2B зээлийн үйлчилгээ 2024.01.26–ны өдөр сэндбокс зохицуулалтын орчинд орсон.

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ

Репо хэлцэл зуучлалын үйлчилгээ нь 2021 оны 12 дугаар сард сэндрокс орчинд орсон бөгөөд мөнгөний захад хадгаламжийн сертификат, арилжааны бичиг, факторинг (хямдруулсан нэхэмжлэл), итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлэх төлбөр тооцоо, бүртгэл, хадгалалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн туршиж байна.

Хадгаламжийн сертификат

2023 оны 9 дүгээр сараас эхлэн Хадгаламжийн сертификат арилжаалагдаж эхэлснээс хойш 2024 оны I улирлыг хүртэлх байдлаар нийт 69.6 сая төгрөгийн Хадгаламжийн сертификат арилжаалагдсан байна.

Анхдагч
арилжааны дүн

57.5 сая

Хоёрдогч
арилжааны дүн

12.1 сая

Итгэлцэл



2023 оны 10 дугаар сард Итгэлцлийн арилжааг шинээр эхлүүлснээс хойш 2024 оны I улирлыг хүртэлх байдлаар нийт 2.3 тэрбум төгрөгийн итгэлцлийн үйлчилгээг зуучилсан байна.

р Анхдагч
арилжааны дүн

1.4 тэрбум

Хоёрдогч
арилжааны дүн

86 сая



Худалдагч



1111

удаагийн хэлцэл



Платформ

Худалдан авагч



214.1 тэрбум
төгрөгийн арилжаа

Репо хэлцэл зуучлалын платформ дээр өнгөрсөн хугацаанд 39 зээлдүүлэгч, 31 зээлдэгч нийт 214.1 тэрбум төгрөгийн 1111 удаагийн арилжаа хийсэн байна. Мөн 2024 оны I улиралд мөнгөний зах нь нийт 170 удаагийн 100.4 тэрбум төгрөгийн илүүдэл нийлүүлэлт, 4 удаагийн 700 сая төгрөгийн илүүдэл эрэлттэй байсан. Репо хэлцлийн платформоор хийгдэж буй зээлийн дундаж хугацаа 37 хоног, харин репо зээлийн дундаж хүү 17.7 хувьтай байна.



Репо зээлийн дундаж хүү

17.7%

Репо зээлийн дундаж хугацаа **37** хоног

7 хоног

14 хоног

28 хоног


84 хоног

2024 оны I улирлын тоог 2023 оны мөн үетэй харьцуулахад арилжааны тоо буурч, бусад үзүүлэлт өссөн байна.

Хугацаа	Зээлдүүлэгчийн тоо	Зээлдэгчийн тоо	Арилжааны тоо	Арилжааны дүн	Дундаж хүү	Зээлийн дундаж хугацаа
2023 оны I улирал	18	14	149	30,120,000,000	17.2	31
2024 оны I улирал	21	20	139	34,350,000,000	17.7	37

Мөнгөний захын I улирлын хүүгийн түвшин болон арилжааны дүнг харуулав. 2024 оны I улиралд мөнгөний зах дээр хийгдсэн нийт репо хэлцлийн дүн өмнө жилийн мөн үетэй харьцуулахад 14 хувиар буурч, 34.35 тэрбум болсон байна. Өмнө онуудын I улиралд хийгдсэн нийт репо хэлцлийн 63.8 хувийг 4 долоо хоногийн хугацаатай, 17.3 хувийг 12 долоо хоногийн хугацаатай, 13.9 хувийг 2 долоо хоногийн хугацаатай, 5.0 хувийг 1 долоо хоногийн хугацаатай репо хэлцлүүд тус тус эзэлж байна.

Зураг. Мөнгөний захын хүүгийн түвшин ба арилжааны дүн, репо зээлийн хугацаагаар



Репо зээлийн энэ улиралд биелсэн хэлцлийн тоо болон арилжааны дүнг 2023 оны мөн үетэй харьцуулахад биелсэн хэлцлийн тоо 10-аар буурсан боловч нийт арилжааны дүн 14 хувиар, жилийн жигнэсэн дундаж хүү 0.5 пунктээр өссөн байна.

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ

Хамтын санхүүжилтийн үйлчилгээ нь 2022.12.30–ны өдрөөс эхлэн сэндрбоксын орчинд орж хамтын санхүүжилтийн үйлчилгээ буюу краудфандинг үйлчилгээгээ туршиж байна. Одоогоор 2 байгууллага сэндрбоксын орчинд урамшуулал, зээл, хувьцаа, хандивт суурилсан хамтын санхүүжилтийн үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.



2024 оны I улирлын байдлаар урамшуулалд суурилсан хамтын санхүүжилтийн 16 төсөлд 374 хөрөнгө оруулагчаас нийт 116.2 сая төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлснээс 111.8 сая төгрөгийн урамшуулалт санхүүжилтийн төсөл амжилттай хэрэгжсэн. Төслүүдийн хувьд дунджаар нийт шаардлагатай санхүүжилтийг 41.6 хувийн биелэлттэйгээр босгосон.


Платформоор санхүүжилт босгосон эдгээр 16 төслийн 8 төсөл нь 1 сараас бага хугацаатай төслүүд бөгөөд төслийн дундаж хугацаа 28 хоног байна.

Хандивт суурилсан хамтын санхүүжилтийн 10 төсөл нийтлэгдсэн бөгөөд нийт 1474 оролцогчоос 47.6 сая төгрөгийн хандивыг босгосноос 11.5 сая төгрөгийг амжилттай хандивласан.

Зээлд суурилсан Зээлийн 1 төсөл хэрэгжиж 2 хөрөнгө оруулагчаас 11 сая төгрөгийн санхүүжилт босгосон байна.





Хөрөнгө оруулагчид насны бүлгээр



Платформоор дамжуулсан урамшуулалт санхүүжилтийн төслүүдэд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдын 70 хувь нь 18–35 нас, 21.7 хувь нь 36–45 нас, 6.1 хувь нь 46–55 нас, 2.2 хувь нь 55–аас дээш насныхан байна.

P2P зээлийн үйлчилгээ

P2P зээлийн үйлчилгээ нь 2022 оны 12 дугаар сард Сэндбоксын орчинд орсон бөгөөд Сэндбокс зохицуулалтын орчинд үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах хүсэлтийг гаргаж тус хүсэлтийн дагуу 2024 оны Санхүүгийн зохицуулах хорооны даргын 33 дугаар тушаалаар сэндбоксын хугацааг сунган хиймэл оюун ухаан, блокчэйн технологийг зээлийн үнэлгээ, бүртгэлдээ ашиглан хөрөнгө оруулагч, зээлдэгч хоёрыг шууд холбох үйлчилгээг хөгжүүлэн хоёр дахь жилдээ туршиж байна.



98.8%
зээлдэгч



1.2%
хөрөнгө оруулагч

P2P зээлийн үйлчилгээ нь 2023 оны 2 дугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2024 оны II улирлын байдлаар тус платформоор 8099 харилцагч P2P зээлийн үйлчилгээг хүртжээ. Эдгээр харилцагчдын 1.2 хувь нь хөрөнгө оруулагч, үлдсэн 98.8 хувь нь зээлдэгч байна.

Платформоор нийт 2.6 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс 2.2 тэрбум төгрөгийн зээл нь эргэн төлөгдөж P2P-ийн зээлийн үлдэгдэл 377.3 сая төгрөг байна. Мөн олгосон зээлийн багцын 76.4 хувийг 3 сараас бага хугацаатай, 14.8 хувийг 4–6 сарын хугацаатай, 8.8 хувийг 7–9 сарын хугацаатай зээл бүрдүүлж байна. Харин тус платформоор дамжсан хөрөнгө оруулалтын багцын 42.0 хувийг 1 жилийн хугацаатай, 58.0 хувийг 1 жилээс бага хугацаатай хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.



1–12 сарын хугацаатай




Зээлийн ЖДХ 1.9%




Хэвийн

98.4%



Хугацаа хэтэрсэн

0.6%



Чанаргүй

1.0%

P2P платформоор зуучлагдан олгогдсон нийт зээлийн үлдэгдлийн 98.4 хувь нь хэвийн, 0.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.0 хувь нь чанаргүй гэсэн тус тус ангилалтай байна. Мөн P2P зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 1.9 хувь байна.

ЭМЭГТЭЙ



64.9%

ЭРЭГТЭЙ



35.1%

P2P зээлийн үйлчилгээний нийт харилцагчдын 64.9 хувь нь эмэгтэй, 35.1 хувь нь эрэгтэй байна. Харин нийт харилцагчдын 52.3 хувийг 18–35 насныхан, 33.4 хувийг 36–45 насныхан, 11.8 хувийг 46–55 насныхан, 2.5 хувийг 55–аас дээш насныхан тус тус бүрдүүлж байна. Харилцагчдыг боловсролын түвшнээр ангилбал 62.1 хувь нь дээд, 4.1 хувь нь тусгай дунд, 28.3 хувь нь бүрэн дунд, 4.4 хувь нь дунд, 1.1 хувь нь бага боловсролтой байна.

Насны бүлгээр

18–35 нас



52.3%

36–45 нас



33.4%

46–55 нас



11.8%

55–аас дээш



2.5%

Боловсролын түвшнээр



Дээд

Тусгай
дундБүрэн
дунд

Дунд

Бага

62.1%

4.1%

28.3%

4.4%

1.1%

СЭНДБОКСОД ТУРШИГДАЖ БУЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

В2В зээлийн үйлчилгээ

В2В зээлийн үйлчилгээ нь 2024 оны нэгдүгээр сард сэндрбоксын орчинд орсон. Тус үйлчилгээ нь аж ахуй нэгжүүдийн богино хугацаат санхүүжилтийн хэрэгцээг хангах, байгууллагуудын харилцах дансанд буй илүүдэл нөөцийг эргэлтэд оруулах замаар зах зээл дэх эх үүсвэрийг үр ашигтайгаар ашиглах боломжийг олгох юм.

**36****Бүртгэлтэй
харилцагч****4.7 тэрбум****В2В зээлийн
олгосон дүн**

В2В зээлийн үйлчилгээ нь 2024 оны хоёрдугаар сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2024 оны 2 дугаар улирлын байдлаар тус платформд бүртгэлтэй 36 харилцагч байна. Платформоор нийт 20.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон бөгөөд үүнээс 1.9 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Мөн В2В зээлийн дундаж хүү 1.5 хувьтай байгаа бол хугацааны хувьд 14, 21, 28 гэсэн хоногуудтай байна.



В2В зээлийн хугацаа

14, 21, 28 хоног

В2В зээлийн дундаж хүү

1.5%

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Зохицуулалтын орчны сайжруулах ажлын хүрээнд:

“Азийн Хөгжлийн Банк (АХБ)”-ны санхүүжилттэй “Монгол Улсад финтек салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг хөгжүүлэх мэргэжлийн болон техник туслалцааны хөтөлбөр төсөл” **(1)** Монголын финтек, инновацын экосистемийг хөгжүүлэх замын зургийг боловсруулах, **(2)** Санхүүгийн хяналт, шалгалтад суптекийг нэвтрүүлэхэд шаардлагатай үнэлгээний болон бодлогын зөвлөмжийн тайланг боловсруулах, зорилготойгоор 2025 оныг хүртэл хэрэгжих ба төслийн үндсэн хэрэгжүүлэгчээр Санхүүгийн зохицуулах хороо, хамтран хэрэгжүүлэгчээр Монголбанк, Сангийн яам ажиллаж байна.

Түүнчлэн сэндроксод оролцогч компаниуд хяналтын системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж байна. Ингэснээр оролцогч компаниудыг бодит цагийн тоон мэдээллийн дагуу хянах боломжийг олгох юм.

Сэндроксын орчны олон нийтэд таниулах ажлын хүрээнд:




Финтек компаниуд болон хэрэглэгчдийн кибер аюулгүй байдлыг хангахад тулгарч буй асуудлыг хэлэлцэх, шилдэг туршлагыг хуваалцах, зохицуулалтын шаардлага, хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл өгөх “Finsec” форумыг Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв, Санхүүгийн зохицуулах хороо, Финтекийн холбоо хамтран зохион байгуулсан.

Сэндроксын орчны оролцогчдод хяналт тавих, хамтран ажиллах ажлын хүрээнд:



2024 оны I улирлын байдлаар Сэндрокс орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтэй нийт 25 компанитай 66 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.

Оролцогчдоос ирсэн тайлан мэдээнд суурилан зайны хяналтыг тогтмол гүйцэтгэн, газар дээрх хяналт, үзлэгийг мөн гүйцэтгэн ажиллаж байна.

Финтекийн хөгжил болон зохицуулалтын орчны талаарх цахим болон танхимын сургалт, уулзалтуудад тогтмол оролцож байна.



Сэндроксод туршигдаж буй 6 бүтээгдэхүүн тус бүрд тохирсон тайлан, мэдээний маягыг боловсруулан 7 хоног, сар, улирлын тайлан, мэдээг төвлөрүүлэн тоон мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.



Сэндроксод туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улс дахь хөгжил, зохицуулалтын орчны судалгааг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.

